

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-31
1.“Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	8-17
2.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	17-21
3.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	21-22
4.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	22
5.Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан	23-31

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
07 дугаар сарын 07-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Л.Гантөмөр, Ц.Туваан, О.Цогтгээрэл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг 1 дүгээрт оруулж хэлэлцэх горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ажлын хэсгийн зөвлөх У.Хосжаргал оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хороодын ажлын албаны

дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ажлын хэсгийн зөвлөх У.Хосжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Усны тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Төслийн 1 дүгээр зүйлийн ““бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад” гэснийг ““бүсэд” гэсний дараа “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Г.Уянгахишиг нар үг хэлж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Төслийн 1 дүгээр зүйлийн ““бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад” гэснийг ““бүсэд” гэсний дараа “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	8
Бүгд:	18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын дэд дарга Э.Лхагва, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Менежментийн газрын дарга Т.Нармандах, мөн газрын Хүний нөөцийн стратеги, менежментийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Баярмаа, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Гадаад харилцааны газрын дарга П.Баярмагнай, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 25 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Хуралдаандаа ирсэн гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна, Жадамбаагийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн байна, Энхбатын Болормаа гишүүн ирсэн байна, Тогмидын Доржханд гишүүн ирсэн байна, Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн байна, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн гишүүн ирээд байна. Ирээгүй гишүүд Дашзэвэгийн Амарбаясгалан, Сайнбуянгийн Амарсайхан, Батын Батбаатар, Жудагийн Баярмаа, Сандагийн Бямбацогт, Лувсаннямын Гантөмөр, Эрдэнэбилэгийн Одбаяр, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Цэвэгдоржийн Туваан, Ням-Осорын Учрал, Одонгийн Цогтгэрэл, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын гишүүд одоогоор ирээгүй байна. Ирээгүй гишүүдээ дуудаарай. 1 гишүүн ирвэл ирц хүрэх гээд байна. Батбаатар гишүүн ирснээр, сайд.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Батын Батбаатар гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Энхбатын Болормаа, Тогмидын Доржханд, Сархадын Зулпхар, Лхагвын Мөнхбаатар, Одсүрэнгийн Номинчимэг, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг нарын гишүүд хуралдаан ирж, хуралдааны ирц 52 хувьтай болсон байна. Хурлыг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Дараах 6 асуудлыг хэлэлцэнэ. 1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2025 оны 6 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. 2.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025 оны 6 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. 3.Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 4.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 5.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын

төсөл. 6.Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан гэсэн 6 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу? Баярбаатар гишүүн, Анар гишүүн, Батнайрамдал гишүүд. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Горимын санал байна Байнгын хорооны даргаа. Энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал одоо ингээд удахгүй эхлэх гэж байна. Энэ дээр 2 Байнгын хороо дамнаж хэлэлцэгдэх энэ Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл тухай тогтоолын төслийг хамгийн эхний асуудал болгож хэлэлцэх асуудлын 1 дүгээрт оруулж өгөх горимын саналыг гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Тэгвэл та 2 нэг юм байна шүү дээ? Батнайрамдал гишүүний микрофон.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Даргаа Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийн санаачлагчийн хувьд энэ дээр зарчмын зөрүүтэй 1 дүгээрт санал гарсан. 2 дугаарт ЗГ-аас санал өгсөн байгаа. Тэгэхээр энийг хэлэлцэх асуудлаас хойшлуулаад, дараа нь ажлын хэсэг гаргаад ажиллах саналтай байна. Энийг хойшлуулж өгнө үү гэж, тийм өнөөдрийн хурлаас хойшлуулж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүний гаргасан 3 дахь асуудал буюу төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт оруулж өгөөч гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалтад бэлдсэн. Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар 3 дахь асуудлыг эхний асуудал болгоё гэсэн зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар санал дэмжигдлээ.

Батнайрамдал гишүүний гаргасан горимын саналаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаас хойшлуулъя гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудал батлагдлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын, чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг, Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 173 дугаар захирамжаар

байгуулагдсан Төрийн үйлчилгээнд процессын дахь дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг Төрийн байгуулалтын байнгын хороо болон Инновац, цахим бодлогын байнгын хороодын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хамтарсан хуралдаанаар сонссон хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.3.6-д заасны дагуу дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж байна. Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулна. Анар гишүүний микрофоныг өгье.

Ч.Анар: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 173 дугаар захирамжаар төрийн үйлчилгээг хүн төвтэй болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй процессын дахин инженерчлэлийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан миний бие ажлын хэсгийн ахлагчаар, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Батнайрамдал Мөнхбат, Түвшин, Ундраа, Уянга, Хэрлэн, Цэнгүүн, Энхтүвшин, Лувсанжамц ажиллалаа.

Ажлын хэсгийн хүрээнд олон улсын процессын дахин инженерчлэл хийх сайн жишиг, аргачлалыг судлан, улс орнуудын хэрэгжүүлсэн төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэлийн үр ашиг, өгөөжийг харьцуулсан судалгааг хийхийн зэрэгцээ төрийн цахим шилжилтийн цаашдын хөгжил ба чиг хандлагын судалгааг хийж, төрийн мэдээллийн нэгдсэн архитектур болон enterprise дэд бүтцийн судалгааг тус тус хийж, Монгол Улсад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн эксперт, иргэний нийгмийн байгууллагуудтай уулзаж, санал солилцон сайн жишиг нэвтрүүлж буй хувийн хэвшлийн байгууллагатай газар дээр нь танилцаж, туршлага судлан, ЗГ, Их Хурлын харьяа байгууллагуудад хийгдэж буй төрийн бүтээмж, процессын дахин инженерчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлж буй ажлын талаар төрийн байгууллага албаны хүмүүстэй уулзалт хийж мэдээлэл авч, нөхцөл байдлын судалгаа хийж ажиллалаа.

Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 24 оны гүйцэтгэлийн үнэлгээний тайланд хийсэн байна. Үнэлгээний тайланд дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал, төрийн албаны шинэчлэл, төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөн үе шаттай байхаар дахин инженерчлэл хийж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэнэ гэсэн ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 13,4 хувь буюу үр дүнгүй гэж үнэлжээ. Цахим засаглал төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй процессын дахин инженерчлэл чиглэлийн хүрээнд ИМонголиа блокчэйн цахим засаглал зорилгыг хэрэгжүүлэхэд 6 зорилт төлөвлөсөн ч үр дүнд хүрсэн зорилт байхгүй байна. Мөн төрөөс иргэн бизнест үзүүлж буй үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийх, бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухааныг ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авахад авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулна гэсэн зорилгын хэрэгжилт тэг хувь буюу үр дүнгүй хэмээн тайланд дурдагджээ. Дээрх зорилтуудын хэрэгжилтийг хангасан, тайлагнасан байдал болон төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, процессын дахин инженерчлэлийн хэрэгжилтийн нөхцөл байдлын шинжилгээнээс Ажлын хэсэг дараах дүгнэлтэд хүрчээ.

Үүнд, Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох төрийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд процессын дахин инженерчлэл хэрхэн хийх арга зүйн талаар нэгдсэн ойлголт шийдвэрт хүрээгүй байна. 2 дугаарт төрийн байгууллагад процессын дахин инженерчлэлийн бодлого хүрэх үр дүнг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих тогтолцоо үүсээгүй байгаа нь төрийн байгууллагууд нэгдсэн байдлаар чанартай дахин инженерчлэл хийж, хэрэгжүүлэх боломж бүрдээгүй байна. 3.Төрийн мэдээллийн нэгдсэн системийн архитектур ашиглагдахгүй байгаагаас төрийн байгууллагуудын уялдаа холбоо, зардал, цаг хугацаа, бүтээмжид сөргөөр нөлөөлж байна. Төрийн байгууллагууд процессын дахин инженерчлэлийг хийхдээ хууль, эрх зүйн орчинд хамаарах өөрчлөлтийг бүрэн тусгаагүйгээс зөвхөн цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа буюу автоматжуулалт хийж байгаа нь цогц өөрчлөлт болж чадахгүй байна. Иргэдэд төрийн үйлчилгээг илүү хялбар, хурдан хүндрэлгүй хүргэх ИМонгол платформыг хөгжүүлэн ашиглаж буй боловч энэ нь тодорхой хэмжээний төрийн мэдээллийн нэгдсэн архитектур боловсруулан, төрийн мэдээлэл хоорондын уялдаа, системийг нэгдсэн журмаар хэрэглэгчдэд хүргэж чадахгүй байна.

ИМонгол платформын гол цөм нь Хур систем бөгөөд Хур систем нь өөр, өөр төрлийн байгууллагуудтай холбогдох хүсэлтийн дагуу лавлагаа тодорхойлолтыг авдаг үйлчилгээний хүснэгт илгээдэг суурьтай платформ юм. Төрийн нэгдсэн бүртгэл сан байхгүй ба иргэний нэгдсэн данс байхгүй болсон мэдээллийн аюулгүй байдлын, Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн улмаас мэдээллийн нэгдсэн нэгдмэл байдал давтагдашгүй байдал хангагдаж чадахгүй байдалд хүрсэн байна. Хур системийн ард нэгдсэн өгөгдлийн сан хууль, эрх зүйн зохицуулалтын хувьд байхгүй бөгөөд төрийн байгууллагууд дор бүрдээ тус бүрдээ хөгжүүлж, ашиглаж буй нийт 152 бүртгэлийн мэдээлэл, өгөгдлийн бааз холбогдож ажиллаж байгаа нь төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох хамтын ажиллагааг дэмжих нэгдмэл байдал хангалтгүй, тусдаа системүүд хоорондоо мэдээлэл солилцох боломж хомс, уялдаа холбоогүй ажиллах нь үр ашиггүй байдлыг үүсгэж байна. Иргэд болон төрийн албан хаагчдын технологийн мэдлэг, ур чадвар хангалтгүй байгаа нь процессын дахин инженерчлэл хийхэд хамгийн том хүндрэл учруулж байна. Хувь хүний мэдээлэл, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар ойлголт мэдлэг сул байна. Процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв санхүүжилт дутагдалтай байгаагаас төрийн байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэх боломж бүрдэхгүй байна гэж тус тус дүгнэлээ.

Иймд ажлын хэсгийн зүгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хүн төвтэй үзэл баримтлалд нийцсэн, төрийн үйлчилгээг иргэнд хүргэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх болон иргэн, аж ахуйн нэгж, төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, процесс суурьтай, оновчтой, үр ашигтай засаглалыг бэхжүүлж, хөгжлийн бодлого, тухайн салбар, төрийн байгууллагын стратеги, дижитал шилжилт, хууль, эрх зүйн орчин дахь өөрчлөлтүүдийг цогцоор нь уялдуулж, иргэн, хувь хүний хэрэгцээнд тусгайлан тохируулсан өгөгдөлд үндэслэсэн, практик төрийн үйлчилгээг бий болгох арга ажлыг нэгдсэн арга зүйгээр ханган, эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Энэхүү тогтоол нь төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх хамрах хүрээ, үндсэн зарчмыг тодорхойлсон 1 хавсралттай, нэгдсэн удирдлагаар хангах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний үүрэг даалгавар бүхий 9 заалтаас

бүрдэж, хяналт хариуцлагыг хангах хүрээнд тогтоолын хэрэгжилтийг хугацаа зааж, эргэн тайлагнахыг үүрэг болгосон буюу эргэх холбоог хангасан болно. Ажлын хэсгийн зүгээс 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Төрийн байгуулалтын болон Инновац, цахим бодлогын байнгын хороодын хамтарсан хуралдаанаар ажлын хэсгийн дүгнэлт, саналыг танилцуулж, холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг сонсож, гишүүд асуулт асууж, хариулт авснаар Ажлын хэсгийн зүгээс боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжсэн болно.

Эрхэм Байнгын хорооны гишүүд ээ,

Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ц.Сандаг-Очир: Анар гишүүнд баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн асуултаа асууя. Зулпхар гишүүн асуултаа асууя. Яагаад хоёулаа байхгүй болчхов? Ирцээрээ Зулпхар гишүүн юм байна.

С.Зулпхар: Баярлалаа. Ажлын хэсгийнхнээс би нэг зүйлийг зүгээр тодруулах гээд байна л даа. Энэ процессын дахин инженерчлэлтэй зэрэгцээд бид нөгөө урьд нь түгээмэл ашиглаж байсан 2 хийдэг ажил байдаг шүү дээ чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны шинжилгээ гээд энэ 2 зүйлийг. Тэгэхлээр энэ процессын дахин инженерчлэл дотор чинь саяын аргачлалууд нь байгаа юу, тэрийгээ хэрэглэж байгаа юу гэдэг нэг ийм асуулт гарч ирээд байна л даа? Тэгээд урьд нь хийж байсан тэр чиг үүргийн шинжилгээ хийгээд бид ажлын байрны шинжилгээ хийгээд болоод байдаг байсан л даа. Тэгэхлээр энэ процессын дахин инженерчлэлийн давуу тал нь юундаа байгаа юм байна гэдэг нэг ийм асуулт гарч ирээд байгаа юм?

2 дугаарт бид нэг ийм тогтоол гаргаад, төрийн байгууллагууд бүгдээрээ процессын дахин инженерчлэл хийх юм байна шүү дээ. Тэгэхээр бид ямар хугацаа тодорхойлох юм, тогтоох юм бэ? Тэгээд тэр хугацаанд инженерчлэлийн энэ процессын дахин инженерчлэлийг хийх бидэнд хүний нөөц, мэргэшсэн хүний нөөц эсвэл энүүгээр ямар нэгэн байдлаар туршлагатай л хүн байх ёстой шүү дээ хүмүүс. Тэд нарыгаа яаж бэлдэх юм, яаж зохион байгуулахаар та бүхэн бодож байгаа юм гэсэн ийм асуулт байна?

Ц.Сандаг-Очир: Анар гишүүн хариулъя.

Ч.Анар: Ажлын хэсгийн гишүүдийг оруулж өгөхийг Байнгын хорооны даргаас хүсье. Зулпхар гишүүний асуултад хариулъя. Их Хурлын тогтоол үндсэндээ нэгдсэн арга зүй, үзэл баримтлалыг, чиглэлийг нь зааж өгч, удирдамж баталж байгаа. Тэгэхээрээ таны хэлж байгаа салбар яамд, байгууллагуудын чиг үүрэг бүхий дотоод процессын нарийн уялдааг Их Хурлын тогтоолоор батлахгүй. Үндсэндээ ямар чиг үүрэг, арга зүй, үзэл баримтлалаар хийх ёстой юм бэ гэдэг үндсэн ерөнхий зарчмыг баталж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл 2022 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар анх эхлүүлсэн процессын дахин инженерчлэлийг 2 яаман дээр хэрэгжүүлсэн. Үүнээс үүдээд ямар асуудал үүдсэн юм бэ гэхээр өнөөдөр 2024-өөс 2028 оны 3Г-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт процессын дахин инженерчлэл хийх чиглэл орсон.

Гэхдээ процессын дахин инженерчлэлийг төрийн байгууллагууд яамнууд маань бүгдээрээ өөр өөрөөр ойлгоод байгаа юм. Өөр өөрөөр ойлгосноос үүдээд зарим нь автоматжуулалтыг хийж байна, зарим нь санхүүгийн системдээ өөрчлөлт оруулж байна. Гэхдээ эргээд төрд байгаа мэдээллийг иргэн төрөөс, аж ахуйн нэгж төрөөс үйлчилгээ авахдаа хууль дүрэмд заасныхаа дагуу яам, салбар төрийн байгууллага тус бүрээс нь авч, төрд байгаа мэдээллийг эргэж нэгтгэж, хүсэлт, үйлчилгээ аваад байгаа нь хүндрэлтэй байгаа юм. Энэ нь өнөөгийн хууль тогтоомж, төрийн байгуулалтын бүтцээрээ болохгүй байгаад байгаа учраас процессын дахин инженерчлэл гэдэг маань хамгийн эхэнд хийгдэх ёстой асуудал маань төр өөрөө хууль тогтоомж, бүтэц бүрэлдэхүүнийхээ хувьд дүн шинжилгээ хийе гээд хүн төвтэй буюу илүү хяналт суурьтай биш, хүн төвтэй иргэндээ зориулсан үйлчилгээг шуурхай хүргэхэд чиглэсэн үзэл баримтлалыг баталж байгаа юм. 2020, энэ тогтоолын төсөл дээр 2026 оны хаврын чуулганаар ЗГ-т таны асууж байгаа процессын нарийвчлалыг харьяа яамд энэ үзэл баримтлал дээр суурилад болговсруулаад, судалгаагаа хийгээд оруулж ирэх удирдамжийг өгч байгаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Ойлголоо. Тэгэхлээр яах вэ тэр нөгөө 2 яаман дээр хийсэн гээд байгаа шүү дээ 2 яамны харьяа агентлагууд дээр хийсэн. Тэгээд тэр үеийн гарсан тайлантай холбогдуулаад их тийм хэлэлцүүлэг өрнөж байсан юм л даа. Тэр хэлэлцүүлэг нь юу гэж өрнөж байсан гэхлээр зэрэг чиг үүргийн шинжилгээ хийж байснаас зарим зүйл нь их ялгаатай гарчихлаа. Зарим нь ч яах вэ их тийм сайн юмнууд гарсан юм шиг байгаа юм. Тэгэхлээр бид түүн дээр тулгуурласан байдлаар удирдамжаа өгөх гээд байна уу, эсхүл зүгээр ерөнхий байдаг нийтлэг хэрэглэдэг зүйл дээр нь, эсхүл арга зүй дээр нь тулгуурласан байдлаар бид удирдамж гаргаж өгөх гээд байна уу? Энэ үзэл баримтлал гэдэг юм уу энэ зүйлийг яаж гаргаж байгаа юм гэсэн нэг ийм асуулт байна гэж байгаа юм?

Дараа нь бидний энэ гаргасан тогтоолын дагуу ийм дараа нь аргачлал бий болох юм байна гэж байгаа юм. Тэгэхээр тэр аргачлалыг яах юм бэ? Туршиж байгаад бүгдийг нь хэрэглэх юм уу, эсвэл яах юм гэдэг нэг ийм та бүхэнд төсөөлөл байгаа юм уу? Ер нь ямар хугацаанд бид энэ ажлыг цаашдаа ер нь хийж дуусах бол?

Ц.Сандаг-Очир: Анар гишүүн хариулъя.

Ч.Анар: Таны асуултад хариулахад аргачлал, үзэл баримтлалыг боловсруулахаас гадна бид нэгдсэн арга зүй, удирдамж боловсруулсан. Энэ дээр Их Хурлын түүхэнд нэлээн хууль, эрх зүйн хүрээнд нэгдсэн удирдамж, арга зүйг хэрхэн боловсруулах вэ гэдэг нэлээн том эрх зүйн гаргалгаанууд гаргасан байгаа юм. Өөрөөр хэлбэл Монголын төрийн институтүүд өөрөө ганц ЗГ-аар тогтохгүй, Их Хурал, Их Хурлын харьяаны байгууллагууд, Дээд шүүх, шүүхийн харьяаны байгууллагууд гэсэн бүтэцтэй байдаг. Үүнээсээ төрийн тогтолцоо бүтдэг. Хэрэв ЗГ нь болон Их Хуралд нэгдсэн журмаар энэ аргачлал, удирдамж, арга зүйгээр хангахгүй бол хоорондоо өөр ойлголттойн улмаас байгууллага болгон өөр өөрийнхөө аргачлал, арга зүйгээрээ процессын дахин инженерчлэл хийгээд байгаа нь үндсэндээ сууриараа бид процессыг нь төрийн үйлчилгээг хялбаршуулж

чадахгүй юм байна гээд дүгнэлт гаргасан юм. Тийм учраас Их Хурлын ажлын хэсэг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмж ажлын хэсгээс хариулъя гэж байна. Улсын Их Хурлын Тамгын газрын Хосжаргал зөвлөх. Ажлын хэсгийн 2 уу, 3 уу? 2 номерын микрофон.

У.Хосжаргал: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн зөвлөх Хосжаргал. Бид энэ процессын дахин инженерчлэлийг 2 яаман дээр хийж, мөн удирдамжийг боловсруулахдаа гол тусгаж байгаа асуудал энэ тогтолцоо байгаа. Тогтолцоо дээр урт хугацааны буюу 20 50 стратегийг баримталж бодлого, бүтэц зохион байгуулалт, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг тодорхойлох процесс зургийг зураглах, хууль, эрх зүйн орчинд тулгамдаж байгаа асуудлууд, дижитал шилжилт гээд ингээд цогц байдлаар энэ тогтолцооны хэсгүүд болж орж ирж байгаа. Энэ нь ажлын байрны зураг авалт болон нэгжүүдийн дүн шинжилгээтэй нэг дэх хэсэг байгаа. Тэрнээс илүү тодорхойлогдох маш олон асуудлууд гарч ирж байгаа. Ингэснээрээ бид түрүүн ажлын хэсгийн ахлагч Анар гишүүн хэлсэн байгаа энэ нэгдсэн enterprise архитектур луу орох, нэгдсэн дата анализ хийх, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах нөхцөл бололцоо нь үүсэж байгаа юм. Одоогоор арван хэдэн байгууллага хийж байгаа боловч яг нэгдсэн зохион байгуулалтгүйгээс болоод хооронд.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ оруулж ирж байгаа тогтоолын төсөл маш ач холбогдолтой, цаг үеэ олсон, чухал чиглэл өгөх тухай энэ тогтоолын төсөл гэж дэмжиж байна. Ер нь 126 гишүүнтэй парламент бүрэлдэн бий болсон цагаас эхлээд Улсын Их Хурлын даргын захирамжаар нэлээдгүй олон ажлын хэсгүүд байгуулагдаж, чиглэл бүр дээрээ ингэж судалгаа хийж, зарим нь хууль, зарим нь тогтоол болоод ингээд явж байгаа энэ үр бүтээлтэй ажлын нэг нь өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал гэж би дүгнэж байна. Өнөөдөр хүн төвтэй хуультай болно гэдэг гол стратеги дээрээ тулж бид энэ асуудлуудаа үзэж байгаа юм.

Дээр нь энэ төрийн албан хаагч гэж энэ төрийн албаны байгууллага маань өөрөө чадамжтай байх ёстой, чадвартай байх ёстой, дархлаатай байх ёстой. Хөгжлийн хөтөлбөр гээд бид саяхан баталсан. 9 хувь төрийн албан хаагчийн орон тоог бууруулна гээд баталчихсан. Тэгээд ингээд яг 9 хувь яаж бууруулах гээд байгаа аргачлал нь байдаггүй, квот өгөөд яваад байдаг. Тэгээд энэ дахин инженерчлэл дээрээ зөвхөн үйл ажиллагаа дээрээ явж байна уу, эсхүл энэ хүний нөөцийн бодлого өөрөө давхар орж ирэхээр байна уу гэдэг асуудал 1 дүгээр асуудал?

2-т энэ төрийн өмчийн компаниуд яах юм бэ ер нь? Хамгийн данхар бүтэцтэй энэ байгууллага чинь төрийн өмчит компаниуд л байгаа шүү дээ. Цалин пүнлүүний хувьд ч тэр, тэгээд энэ зарим нэг боломжтой энэ төрийн өмчийн компаниудыг хувьчлах ийм инженерчлэлийг явуулах боломж байна уу? Жишээлбэл энэ Төрийн банк. Өнөөдөр яг Хаан банктай адилхан бүтэцтэй, салбартай. Гэтэл Хаан банкнаасаа 20 дахин бага ашигтай ажилладаг. Төр заавал ийм банктай байх ёстой юм уу? Энэ зарим нэр дурдвал энэ авто нөгөө юу билээ нөгөө бааз, Засгийн бааз гэж яриад байдаг. Тэгээд эдгээр зүйлүүдийг ингээд инженерчлэл хийгээд, энэ

төрийн өмчит компаниудыг 1 дүгээрт нээлттэй болгох боломжтойг нь, 2 дугаарт энэ зарим нэгийг нь хувьд шилжүүлэх энэ хувьчлалын асуудлуудыг энэ инженерчлэлийнхээ хүрээнд авч үзэх ийм боломж байгаа юу гэдэг 2 дахь асуулт байна?

Ер нь цаашдаа бид энэ төрийн албаа чадамжтай, чадвартай, иргэдэд хүнд сурталгүй, үйлчилгээ нь илүү ойлгомжтой энгийн байлгах ийм инженерчлэлийг зайлшгүй хийх шаардлага байгаа. Тэгэхдээ бид өнөөдөр энэ Монгол төрийн гол дархлаа энэ төрийн алба гэдэг зүйл дээрээ ямар нэгэн байдлаар төсөв дагуулж ч юм уу, ямар нэгэн байдлаар зарчим алдагдуулдаг ийм зүйлийг дараа дараадаа энэ парламент хүлээн зөвшөөрөх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр эдгээр дээр нэг тийм бодлого гаргаж ажиллахгүй бол төсөв өргөн барьдаг, дагаад нэг Төрийн албаны хууль ч юм уу нэг зарчим алдагдуулсан ийм нөхцөл байдал орж ирээд байгааг хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Анар гишүүн хариулъя.

Ч.Анар: Баярбаатар гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт төрийн процессын дахин инженерчлэлийг хийх Ажлын хэсгийн дүгнэлт тогтоолын төсөл дээр нөгөө 9 хувийг төрийн албан хаагчдыг цомхотгоно гэдэг нэг ч дүгнэлт байхгүй. Тэгэхээрээ ЗГ өөрөө төсвийн хэмнэлт, цомхотгол хийхдээ процессын дахин инженерчлэлийн дагуу гэж яригдаад дурдаад байгааг нэлээн хэд сонссон. Гэхдээ манай ажлын хэсгийн дүгнэлт болон Их Хурлын тогтоол дээр төрийн албан хаагчдыг 9 хувь цомхотгох талаар нэг ч үг, өгүүлбэр, санал, дүгнэлт байхгүй байгаа. Энийг албан ёсоор хэлье.

2 дугаарт энэ процессын дахин инженерчлэл гэхээрээ нэг нийтлэг ойлголт байгаа. Төрийн албан хаагчдыг ажилгүй болгох гэж байна гэж энэ сэтгэхгүй ойлголт байгаад байгаа. Энэ тийм биш юм. Эргээд илүү төрийн албан хаагчид, нийгмийн албан хаагчдын энэ ялгавартай зүй тогтлыг гаргаж өгөөгүйн улмаас Монгол Улсын нийгэмд энэ 224 төрийн албан хаагчийн ихэнх нь багш, эмч байгаа шүү дээ. Хүн ам өсөж байна, боловсрол, эрүүл мэндийн салбар өсөж байна. Энэ нийгмийн салбарын албан хаагчийн тоо өсөж байгаа нь өөрөө төрийн албан хаагчийг том харагдуулаад байгаа. Яг нийгмийн салбарын албан хаагчдыг ялгаад харвал төрийн албан хаагчдын орон тоо дутагдалтай байгаа. Тэгэхээр бид энэ төрийн албан хаагчдыг шинэ цаг үе, технологи, нийгэм цаг үеийнхээ жишгийг дагаад илүү бүтээмжтэй, дахиад сэтгэл ханамжтай, маш олон төрийн процессууд, хууль дүрэм, журам хяналтынхаа улмаас тодорхойгүй байдаг. Түүн дээрээ төрийн албан хаагчид маань маш өндөр ачаалалтай ажилладаг. Тэрийг илүү тодорхой болгоод, илүү бүтээмжтэй, илүү сэтгэл ханамжтай болгох ажлыг л хийгдэж байгаа юм шүү. Тэгэхээр үүн дээр энд үзэл баримтлал, зарчим дээр энийг тодорхой зааж өгсөн байгаа.

Баярбаатар гишүүний 2 дахь асуултад төрийн өмчит компани дээр би тантай яг санал нэг. ТӨК маш олон давхардсан чиг үүрэгтэй, маш олон зүйлүүдийг хийж байна. Гэхдээ энэ ажлын хэсгийн чиг үүргийн хүрээнд бид цаашид үргэлжлүүлэн төр ер нь яг юу хийх ёстой, юу хийх ёсгүйг тодорхойлох ёстой байгаа юм. Тэр бол гарцаагүй үнэн. Гэхдээ энэ суурь асуудлуудыг бид ойлгож, төр яг иргэндээ ямар үйлчилгээгээ хийгээд, юуг нь хийхгүй байх ёстой, давхардсан чиг үүргийг яаж арилгах ёстой вэ гэхээрээ энэ ажлын хэсгийн гаргасан тогтоолын дагуу Их Хурлын гаргасан баталсан тогтоолын дагуу ЗГ өөрсдөө чиг үүргийн судалгаагаа хийгээд,

26 оны хавар танилцуулах, түүнийхээ дагуу үр дүнг нь, хэрэгжилтийг нь Байнгын хороод хянахаар оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн тодруулъя.

Б.Баярбаатар: Тийм дахин инженерчлэл гэдэг зүйлээ яг янз бүрээр ойлгоод байгаа юм. Энэ нэг ойлголтыг нэгтгэх ийм зайлшгүй шаардлага хамгийн эхний ажил байгаа юм. Тэгээд энэ дахин инженерчлэлээ холбогдох төрийн байгууллагууд дээр хийгдэхээр нэг загвар гараад ирж байгаа юм. Чиг үүргийнхээ хувьд, үйл ажиллагааныхаа хувьд. Энэ дээр чинь уялдаад энэ байгууллага бол яг ийм чиг үүрэгтэй, ийм үйл ажиллагаатай явах юм байна гээд ардаас нь яг хүний нөөцийн бодлогын асуудал орж ирж байгаа байхгүй юу. Энэ дээрээ суурилж. Эхлээд бид хүний нөөцийн бодлогоо эхлээд авч болохгүй. Гэтэл өнөөдөр бид яг яагаад байна гэхээр эхлээд хүний нөөцийн асуудлаа оруулж ирээд байгаа байхгүй юу. Данхар байна, данхар байна гээд л бууруулна тэдэн хувь бууруулна, тэдэн хүн цөөлнө гээд ийм автомат тоо яриад, тэгээд эндээсээ яг үнэхээр гол хэрэгтэй өнөөдөр чиг үүргийнхээ хувьд байх ёстой хүмүүс нь өнөөдөр орон тооны цомхотголд орчих ийм эрсдэл үүсчхээд байгааг л би хэлээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ нэг загварчлалаа бид хурдан гаргаад, энэ дээрээ суурилсан ийм хүний нөөцийн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй. Зулпхар гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүн микрофон өгье.

С.Зулпхар: Тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Тэр саяын асуулт би нөгөө тодорхой зүйлээр л хариултаа авах гээд байгаа асуулт юм байгаа юм. Их тодорхой хариулт авчихлаа гэж бодож байна. 1 дүгээрт энэ тэр бид энэ нөгөө төрийн албан хаагчдыг 9 хувь цомхотгохтой холбоотой асуудал энэнтэй холбоогүй гэдгийг бид бүгдээрээ хүлээн зөвшөөрлөө. Тэр бол тэртээ тэргүй чиг үүргийн шинжилгээгээрээ, ажлын байрны шинжилгээгээрээ хийгдэнэ. Түүн дээр угаасаа хийж болох 4 арга нь ч гэсэн тодорхой байгаа. Энийг бид зөндөө ярьчихсан шүү дээ.

Харин энэ процессын дахин инженерчлэл бол тухайн төрийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой нарийн шинжилгээ хийгээд, хаана яг ажиллахгүй байгаа юм, хаана ажиллаж байгаа гэдгийг л бид тодорхойлно. Жишээ нь ийм үйлчилгээ байгаа юм. Манай халамжийн үйлчилгээ байдаг юм л даа. Халамжийн үйлчилгээ дээр бид жишээ нь цахимжуулчихсан, жишээ нь халамжийн үйлчилгээг хороон дээрээ цахимжуулчихсан байдаг, дүүрэг дээрээ цахимжуулчихсан байдаг, тэгсэн чинь тодорхой тэр үйлчилгээтэй холбоотой мэдээлэл өөр төрийн байгууллагаас орж ирдэг, тэр нь өөр журмаар бол цахимжаагүй. Аягүй бол жишээ нь хязгаарлагдчихсан байж байгаа. Тэгэхээр энд бол процесс угаасаа ажиллахгүй байна гэсэн үг юм. Тэгэхээр үндсэндээ процессын дахин инженерчлэл бол энийг бүхэлд нь харж байгаад, саяын хэлээд байгаа төрийн албан хаагчдаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг 1 дүгээрт хялбаршуулах, 2 дугаарт төрийн байгууллагууд дотроо тэр мэдээллийг бүрэн солилцоод, тухайн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой процессыг ажилладаг болгох ийм л зүйлийг чухалчилж байгаа учраас энэ өөрөө ер нь төрийн бүтээмж талаасаа, төрийн жишээ нь хүнд суртлын бууруулах талаасаа их чухал ийм аргачлал байгаа гэдгийг мэдэж байгаа юм.

Нийгмийн даатгал дээр хийсэн үр дүнгээ өгсөн, нийгмийн даатгал дээр хийсэн. Анх ингэсэн шүү дээ нийгмийн даатгал дээр хийгээд нийгмийн даатгал дээр маш олон хүн ажилладаг юм байна бараг энийг хийнгүүт хүнгүй болгоно гээд тийм биш байхгүй юу. Тэр чинь нийгмийн даатгал дээр хийсэн цахимжилт гэдэг бол урьд нь үүсэж байсан хүнд суртлыг багасгахын тулд хийсэн, бүх юмыг хялбаршуулах гэж байсан нь энэ цахимжилт байдаг, хүн нь өөрөө хэрэгтэй байсан байхгүй юу. Тэгээд тэрийг инженерчлэл хийсэн чинь энэ байх ёстой юм байна гээд гаргаад ирсэн. Гэхдээ нөгөө талдаа бусад байгууллагуудтай холбоотой тэр процесс дотор хаана, юу болохгүй байна гэдгийг гаргаж ирээд, тэрийгээ бид нэг газар журмаар нь шинэчлэх юм байна нэг газар. Нөгөө тал өөрөө цахим шилжилт хийгээгүй бол нөгөө тал нь цахим шилжилт хийгээд ямар ч нэмэр байхгүй. Хоёулаа зэрэг хийсэн байж энэ ажилладаг. Тэр процессынхоо системийг бүрэн ажиллуулахтай холбоотой ийм шийдэл байхгүй юу. Тэгэхээр энэ үүднээс нь аваад үзвэл сая 2 яамны харьяа агентлаг дээр хийсэн үр дүнгээ бид сайн туршлага болгоод бидэнд цаашдаа ашиглах боломжтой байх. Гэхдээ төрийн байгууллагууд чинь өөрийнхөө чиг үүргийн онцлогоос хамаараад ялгаатай юмнууд байгаа. Тэр ялгаатай байдлыг нь ялгаатай байдлаар инженерчлэлээ хийх байлгүй гэж бодож байна.

Тэгэхээр энэ бид маш чухал ажил хийж байгаа. Та бүхэн энэ дээр арга зүй талаас нь үндэсний хэмжээний, магадгүй энэ чинь орон нутагт ахиад хийгдэнэ. Тэр орон нутагт сургалтуудыг нь хийх чиглэлээр аягүй бол сурагч багшаа бэлдээд, энэ дээр зөвлөөд явдаг улсуудаа бэлдэхгүйгээр хүн нь хүрэлцдэггүй юм билээ л гэж байгаа юм. Хүн үнэхээр хүрэлцдэггүй. Тэгээд ингээд хийгээд явбал болох байх гэсэн ийм бодолтой байна. Тэр албан хаагчдын тоо бол би Баярбаатар даргатай санал нэг байна. Ингээд зүгээр механикаар тэр чинь тооцдог юм ерөөсөө биш шүү дээ. Би урьд нь ч гэсэн хэлсэн. Гаднын улсыг жишиг болгодог ч юм бол биш. Гаднын улс чинь манайхтай харьцуулж болдог, адилтгаж болдог улс байна. Харьцуулж болдоггүй улсууд байгаа шүү дээ. Бид ингээд заримдаа гадна тэгж байна, энэ тэгж байна, тэнд ингэж байна гэж аягүй их ярьдаг. Үгүй ээ, уучлаарай байхгүй ээ, бид чинь өөртөө тохирсон засаг захиргааны шинэ бүтэцтэй, өөртөө тохирсон төрийн байгуулалтын бүтэцтэй, түүндээ тохирсон төрийн байгуулалтын зохион байгуулалт хийж байгаа байхгүй юу. Тэгээд л тэрэндээ тохирсон байдлаар л бид чадлаараа нөөцөө хуваарилж байгаа шүү дээ. Энэ талаас нь зөв ойлгоод, нийгмээрээ зөв ойлгоод явах ёстой байх. Илүү газраа бол илүү байгаа бол тэрийг харин хариуцлагатай жишээ нь ярьж, хариуцах эд нарыг бол багасгадаг ажлаа хийнэ биз дээ. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Миний бие ганц санал хэлье. Анар гишүүн нарын өргөн барьсан энэ Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлын Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа. Энэ маш их чухал асуудал байгаа юм. Уг нь манай гишүүд төдийлөн ач холбогдол өгөхгүй байх шиг байна. Сая төсвийн тодотгол хийж үндсэндээ дуусаж байна. Хөгжлийн төлөвлөгөө баталсан. Энэ болгоноор ингээд л төрийн албан хаагчдын тоог данхар байгааг цомхотгоно, бууруулна, хэмнэнэ гээд л яриад байх шиг байгаа юм. Тэгээд яг Засгийн газар ямар тооцоо судалгаан дээр энэ асуудлыг хөндөж оруулж ирж байгаа юм бэ гэхээр төдийлөн сайн нарийн тооцоо судалгаа байхгүй. Бүх яамнуудыг зүгээр ижилтгээд адилтгаад 9 хувиар бууруулна л гэж байгаа юм.

Тэгээд зарим яамнууд үнэхээр их ачаалалтай, хүн хүчний хэрэгцээ шаардлагатай байгаа, зарим дээр нь илүүдчихсэн гэдэг юм уу, ажлын ачаалал багатай асуудлууд байдаг. Тэгтэл адилтгаад ингээд явж байгаа нь өөрөө энэ нарийн тооцоо судалгаа байхгүй ийм асуудлаас үүдэлтэй. Тэгэхээр яг энэ тогтоолын төсөл яг энэ уг нь бол Анар гишүүн нарын энэ тогтоолын төслийн дагуу дахин инженерчлэл хийгээд хаана, аль яаманд, аль газарт ажлын хийдэл, давхардал, сул орон тоонууд байна вэ гэдгийг гаргаж ирсний үндсэн дээр ЗГ харин энэ бүтцийн гэдэг юм уу, энэ цомхотгол, орон тооны асуудлуудыг ярих ёстой юм байгаа юм. Гэтэл ийм асуудалгүйгээр ингээд үндсэндээ бараг эсрэгээрээ л явчихлаа л даа. Тийм учраас цаашдаа ингэж дахин инженерчлэл хийж байж, төрийн алба хаана нь хүн хүчний хэрэгцээ байна вэ, магадгүй зарим газар 19, 29 хувиар орон тоог цомхотгох асуудал байхыг үгүйсгэхгүй. Зарим газар 9 хувь байтугай 1 хувийг нь ч цомхотгол хийх шаардлагагүй ийм асуудал гарч ирэхийг үгүйсгэхгүй шүү дээ. Энэ хэрвээ дахин инженерчлэл хийвэл. Тийм учраас энэ асуудлууд дээр цаашдаа ингэж хандах.

Нөгөө талаар сая тодотгол хийхээр иргэдийн зүгээс ямар гомдол байна вэ гэхээр төрийн Компанийн тухай хуулиар зохицуулагддаг төрийн өмчийн компаниудын бүтэц, орон тооны асуудлыг яриад байгаа юм. Бид Төрийн албаны хуулиар зохицуулагддаг төрийн 4 чиглэлийн төрийн албаныхныхаа хүрээнд асуудал ярьж байгаа. Гэтэл энэ хэрэгцээгүй, хүнд зориулагдсан орон тоотой байдаг энэ төрийн өмчийн компаниуд дээр бүтцийн тоогоо асуудлаа яриач гээд ингээд байдаг. Энэ асуудал Төрийн албаны хуулиар зохицуулагддаггүй. Дараа нь төрийн өмчийн компани, Төрийн өмчийн хуулиуд дээр хэрэгжих үеэр энэ асуудлуудыг анхаарал хандуулж, энэ дахин инженерчлэлийн асуудал хийвэл илүү нарийн асуудлууд гарч ирэх ёстой. Тийм учраас энэ ЗГ Компанийн тухай хуулийн хүрээнд төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах хүрээнд энэ төрийн үйлчилгээний дахин инженерчлэлийн асуудлыг хийж байж энэ бүтэц, орон тооны асуудлыг хийвэл илүү тодорхой болж гарч ирнэ гэдгийг хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулахаар ирц хүрэхээр байна уу, яахаар байна вэ? Харин тийм, гишүүдээ дууд даа. Анар гишүүн өөрөө орохгүй. 2, 3, 4. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар санал дэмжигдлээ. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүн танилцуулна. Төрийн үйлчилгээнд процессын дахин менежмент хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа, Анар гишүүнд баярлалаа.

15.01 цаг

Хоёр.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

2 дахь асуудалдаа оръё. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ЗГ 2025 оны 6 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсэг танилцуулъя. Х.Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Б.Баттөгс Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 6 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 7 сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн.

ТББХ 2025 оны 7 сарын 7-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан, явуулна, явуулсан. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулалт чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан нэг санал хураалт явуулна. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал нэг санал байгаа. Гүйцээн боловсруулах чиглэлээр. Уянгахишиг гишүүн. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Энэ чинь Усны тухай хууль дээрээ юм биш үү?

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн бүсэд гэсний дараа нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад гэснийг бүсэд гэсний дараа инженерийн болон нийтийн зориулалттай дэд бүтцээс бусад гэж өөрчлөх гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан ажлын хэсэг Хотын дарга Нямбаатар дарга ажлын хэсгийн 5 номерын микрофоныг өгье.

Х.Нямбаатар: Гүйцээн боловсруулах чиглэлийн хүрээнд шууд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.18-д байгаа заалтыг шууд эшлээд явчихъя гэж тэгж ойлголцсон. Энийг нь би яг ингээд уншаад сонсохоор энэ нь аягүй тодорхой заалт байгаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8 дээр нийтийн зориулалттай дэд бүтэц гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц бүтээц бүхий байгууламжийг нийтийн зориулалттай дэд бүтэц гэж ойлгоно гээд шууд юуны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-ыг эшлээд явчихвал бараг амар юм болов уу гэсэн ийм саналтай байгаа.

Ц.Сандаг-Очир: Гүйцээн боловсруулах, зарчмын зөрүүтэй санал гаргасан Уянга гишүүн саналаа тайлбарлая. Уянга гишүүний микрофон.

Б.Уянга: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Сая Нямбаатар даргын хэлсэнчлэн 5.1.8 буюу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн энэ заалтыг шууд эшлээд явъя гээд ярьсан юм. Гэхдээ нийтийн зориулалттай дэд бүтэц гэдэг нэр нь бүтнээрээ орчхож байгаа учраас энийг юу хэлж байгаа вэ гээд үзэхэд хууль, эрх зүйн орчинд тодорхойлогдсон тодорхойлолт учраас нийтийн зориулалттай дэд бүтцээр нь бичээд явах нь асуудалгүй гэж ярилцсан учраас нийтийн зориулалттай дэд бүтэц нь үлдсэн байгаа. Өмнө нь инженерийн болон гэж орсон саналын томъёолол гишүүдэд тараагдсан байх. Энэ бол Барилгын тухай хуулийн 4.1.33 дээр инженерийн дэд бүтцийг тодорхойлж өгсөн байдаг юм билээ. Яг тодорхойлолтыг нь уншихаар инженерийн дэд бүтэц гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц бүтээц бүхий байгууламж гээд.

Нэг нь болохоор яах вэ Барилгын тухай хууль дээрээ инженерийн дэд бүтэц гээд, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дээр нийтийн зориулалттай дэд бүтэц гээд ерөнхийдөө нэг нэгэндээ уусахуйц боловч хоёр хуулийн төсөл дээр хоёуланг дээр нь тодорхойлчихсон нэр томъёо учраас хоёуланг нь авах нь зүйтэй

юм байна гээд хуулийн эхийг барьж байгаа хуульчидтай ярилцаад, тэгээд инженерийн болон нийтийн зориулалттай дэд бүтэц бүтцээс бусад гэсэн томьёолол оруулж ирсэн байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Нямбаатар дарга ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Х.Нямбаатар: Уянга гишүүнээ зүгээр нийтийн зориулалттай гэдгээ яг шууд хууль эшлээд явбал хууль зүйн техникийн хувьд илүү амар гэж би ойлгоод байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл хуулиуд дээр ингээд өөр, өөр зохицуулалт байлгүйгээр хууль зүйн техник талаасаа ч тэр шууд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 1-н 5.1.8-д заасныг, зааснаас бусдыг гээд л явчихаар болчихно гэж би тэгж ойлгоод байгаа юм. Тэгвэл илүү амар. Тэгэхгүй болохоор саяын өөрийн чинь хэлж байгаа томьёоллоор болохоор Барилгын тухай хууль, юуны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хоёрын яг тийм дундын эрлийз хувилбар гарчхаад байгаа байхгүй юу. Магадгүй наадах чинь төрийн үйлчилгээний барилга байгууламж байхыг үгүйсгэхийн аргагүй шүү дээ хэдүүлээ амьдрал баян учраас. Хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд хүртэл тэгсэн шүү дээ. Зөвхөн Улаанбаатар хотын гэдэг үг орж ирэхээр хөдөө орон нутгийн гол дээгүүр гүүр барихад энэ зохицуулалтыг чинь бид ашиглах ёстой шүү дээ гээд. Тэгээд бид тэр саналаасаа татсан.

Тэгээд өнгөрсөн долоо хоногийн 5 дахь өдөр нэгдүгээр хэлэлцүүлгийн дараа би Уянгахишиг гишүүнтэй цуг сууж байгаад тайлбар хийгээд, дахиад тэр тайлбар дээрээ очингуутаа амины болон нийтийн зориулалттай орон сууц гэдгийг бүүр оруулахгүй шүү гэдэг тайлбар хийсэн бас буцсан. Одоо тэгээд хэдүүлээ байгаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-гаа бариад явчихъя. Энэ нь илүү ойлгомжтой. Саяын бүх зохицуулалтууд нэг дор туссан байна л гэж явж байгаа шүү дээ. Тэгээд бид та нарын хэлсэн бүх саналуудыг хүлээж аваад, хамгийн сүүлд нь Уянгахишиг гишүүн бүр хууль дээрээс тэгвэл аль нэг хуулиас эшлэл авъя гэж ярьсан шүү дээ. Тэгэхээр чинь за тэгвэл бид тэгье гээд энэ амралтын өдрүүдээр сууж байгаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-ыг, бид гол нь ажил хийхэд хүндрэл учраад байгаа учраас л энийг оруулж ирж байгаа шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ дээр хагас, бүтэн сайнд Уянгахишиг гишүүнтэй суусан юм байна. Өнөөдөр өглөө би Уянгахишиг гишүүнтэй уулзсан. Дараа нь Хулан референттэй уулзсан. Тэгээд энэ дундаас гарч ирсэн томьёолол юм байгаа юм шүү. Танай ажлыг дэмжиж, тэгэхдээ хуулийн техникийнх нь хувьд зөв болгох гэж суусан. Мэдээж би хуульч биш, тэгэхдээ энд хоёрын хоёр хуульч ажилласан гэдгээ хэлье. Тэгээд Төрийн байгуулалтын дарга өөрөө шийднэ биз ээ.

Ц.Сандаг-Очир: Алив Уянгахишиг гишүүн саналаа тайлбарла даа, Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Тэгэхээр яах вэ нөгөө яг хуулийн тухайлсан хуулийн заалтыг эшилж болно. Бас хууль дээр нэр томьёо нь тодорхой байгаа тохиолдолд шууд оруулж болох юм гэдэг тийм байдлаар нөгөө нийтийн зориулалттай дэд бүтэц гэдгээрээ өөр хууль дээр биш зөвхөн тэнд тодорхойлолттой байгаа учраас оруулаад явчихъя гэсэн юм. Яагаад гэхээр нөгөө Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа эш татчихаар зөвхөн нөгөө буцаагаад төр дангаар хийх биш,

зөвхөн төр, хувийн хэвшлийн хамтынх болчих вий гэдэг утгаараа тэрийг эш татахгүй явчихсан юм. Зүгээр 2 боломж байгаа нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийнхаа заалтыг эш татах, эсвэл анхнаасаа ярьж байснаараа тайлбар гэдэг дээрээ нийтийн зориулалттай дэд бүтэц гэдэгт энэ, энэ, энийг ойлгоно гэдэг маягаар яг энэ хуулийг дангаар нь хэрэглэх боломжтойгоор оруулж болно л доо. Тэгэхээр Байнгын хорооны даргаа одоо хэрвээ Уянгаа гишүүн зарчмын зөрүүтэй саналаа өөрчлөөд, яг тэр нөгөө нэг тайлбарыг илүү тодорхой байлгахыг хүсээд байна л даа ажлын хэсгээс. Тэгэхээр дараа нь маргаан гарахгүй гэдэг утгаараа тэрийг нь яг эшлэл болгоод оруулъя гэвэл зарчмын зөрүүтэй саналаа өөрчлөөд оруулах хэрэгтэй болох уу? Тийм. Би нөгөө, түрүүн би тантай зөвлөлдсөн шүү дээ. Яг энэ нөгөө нийтийн зориулалттай дэд бүтэц гэдэг маань Төр, хувийн хэвшлийн тухай хууль дээр байж байгаа юм. Тэгэхээр яг тэр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д заасан гэдгээр орох уу, эсвэл зүгээр энүүгээрээ явчих уу гээд. Тэгээд ер нь нэгэнт хуульд тодорхойлогдчихсон нэр томьёо учраас энүүгээрээ явахад нэг их тийм ялгаатай зүйл үүсэхгүй, эргэлзээ гарч ирэхгүй гэдэг утгаараа энүүгээрээ шууд цэвэрхэн явчихъя л гэсэн юм уг нь.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг, Уянга гишүүн зарчмын зөрүүтэй саналаа жоохон өөрчилъе гэнэ. Зарчмын зөрүүтэй саналыг нь дахиад уншаадахъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн ““бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад”” гэснийг ““бүсэд” гэсний дараа “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад”” гэж өөрчлөх. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцууллаа. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтад бэлдээрэй. Саяын уншсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдээрэй. Сая та бүхэнд зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулсан. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя гишүүдээ. Баярмаа гишүүн горимын санал гаргая.

Ж.Баярмаа: Сая энэ төхөөрөмж жоохон гацаад татгалзсанаар орчихлоо. Тийм учраас горимын санал гаргая, дахин санал хураалгана уу гэж.

Ц.Сандаг-Очир: Баярмаа гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Баярмаа гишүүний горимын санал 18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар дэмжигдлээ. Үндсэн зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар санал дэмжигдлээ. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Уянга, Алтангэрэл сайд уу, Алтангэрэл гишүүн танилцуулна. Ажлын хэсэгт баярлалаа. Байж байгаарай.

15.22 цаг

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. 3 дахь асуудал. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдээрэй гишүүд. Санал хураалтдаа бэлдээрэй. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 18 гишүүнээс 9, 50 хувь болчихлоо шүү дээ. Уянгахишиг гишүүн горимын санал гаргая.

Г.Уянгахишиг: Уучлаарай, би сая нөгөө санал хураахдаа бэлтгэж амжаагүй байж байгаад хоцорчихлоо. Саналыг дахин хурааж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар санал дэмжигдлээ. Тэгвэл чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя санал. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.25 цаг

Дөрөв. “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулттай гишүүн, асуулт, үгтэй гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж, батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдэх юм байна. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 55,6 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.26 цаг

Тав.Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцье. Ажлын хэсгийг танилцуулъя. Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан Ариунхур Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга, Баасандорж дарга Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Амарбат Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Лхагва Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Дондогмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Бумдарь Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал, Ган-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, технологийн газрын дарга, Нармандах Улсын Их Хурлын Тамгын газрын Менежментийн газрын дарга, Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамжийн хэлтсийн дарга, Баярмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хүний нөөцийн стратеги, менежментийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Барсүрэнгийн Баасандорж танилцуулна. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Баасандорж: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын 2024 оны үйл ажиллагааны товч танилцуулгыг та бүхэнд танилцуулъя. Дэлгэрэнгүй танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Тэгээд дэгээрээ би 10 минутад багтааж танилцуулах ёстой. Би аль болох товчлоод та бүхэндээ 24 оныхоо үйл ажиллагааг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах, хуульд заасан бусад ажлыг эрхлэх үүрэг бүхий Тамгын газартай байна гэж заасан байдаг. Мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Ерөнхий бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулахаар заасан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд танилцуулж байна.

2024 он бол Монгол Улсын парламентын түүхийн нэгэн шинэ эхлэл болсон 126 гишүүнтэй Монгол Улсын Их Хурлын эрх зүйн орчин ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн, зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд төлөвшүүлэн бэхжүүлэх шилжилтийн жилд байснаараа онцлогтой. Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталж, шинэ Улсын Их Хурлын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэ үндсэн дээр Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан 126 гишүүнтэй, улс төрийн 5 нам, эвсэл болон нийгмийн олон бүлгийн төлөөлөл бүхий Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг бодитой хэрэгжүүлэх, хууль тогтоох, хянан шалгах төлөөллийн үйл ажиллагааны уламжлалаа хадгалж, Парламент 2.0 гурван төгөлдөршил бодлогыг хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хуралд

Тамгын газар мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын дэмжлэг, уучлаарай та бүхэн. Техник, зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиглэлээр 2024 онд 268 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр арга хэмжээ гүйцэтгэлийн үнэлгээгээрээ 87,8 хувийн биелэлттэй байна.

Эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын Тамгын газраас 2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг 4 багц хэсэгт хувааж та бүхэнд танилцуулж байна. 1.Монгол Улсын Их Хурлаас хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хуульд 2019, 2023 онд оруулсан өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллалаа. Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулах, Улсын Их Хурлын хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулах, Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахад мэргэжил арга зүйн бүх талын туслалцаа үзүүлж, шинээр бүрдэх Улсын Их Хурлын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлсэн. 2024 онд 475 хууль, Улсын Их Хурлын 140 тогтоол хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлсэн нь 2023 онтой харьцуулахад анхдагч хууль 36,3 хувиар, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 22,4 хувиар, Улсын Их Хурлын тогтоол 13,6 хувиар тус тус өссөн байна.

Мөн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 435 асуудал хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж, зохион байгуулалтын туслалцаа үзүүлсэн нь өмнөх оноос 10,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Байнгын, дэд, түр хорооны 132 тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсны зэрэгцээ хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд нийт 472 санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн нь өмнөх оноос 7,8 хувиар өссөн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хуваарьт заасан 32 хуулиас 2024 онд өссөн хувиар 28 хууль буюу 87,5 хувийг батлан хэрэгжүүлж байна. Парламент.мн системд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 462 хууль тогтоомжийн төслийг, боловсруулж байгаа 130 хууль тогтоомжийн төслийг тус тус байршуулсан. Цахим системээр дамжуулан давхардсан тоогоор 8400 гаруй санал ирснээс 51 саналыг холбогдох хуулийн төсөлд бүрэн тусгасан байна.

Улсын Их Хурал, Байнгын, дэд хороо, Хянан шалгах түр хороо, ажлын хэсэг, гишүүдэд үзүүлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа нэмэгдэж, хүртээмжтэй болж, үр дүнд хүрч байна гэж үзэж байна. Шинэ үеийн парламент 2.0 гурван төгөлдөршил бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгох, хүн бүрд, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг байх, нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцсэн эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргах чиглэлээр Улсын Их Хурлын даргын захирамжаар 60 гаруй ажлын хэсэг байгуулагдан, ажлын хэсгийн 207 удаагийн хуралдааныг зохион байгуулах, 73 танилцуулгыг боловсруулах, олон нийтэд мэдээлэл өгөх зохих туслалцаа, дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын төлөвлөлт, тайлагналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судалж, Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг батлуулах, хэрэгжүүлэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцах, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга уг стратеги, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаар жил бүр Төрийн байгуулалтын байнгын хороонд хариуцан тайлагнадаг байхаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд тусгах саналыг хууль санаачлагчид танилцуулж, шийдвэрлүүлсэн билээ. Үүний үр дүнд Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хугацаанд буюу 2024-өөс 2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлж эхлээд байна. Стратеги төлөвлөгөөг Олон улсын парламентын холбоо болон бусад орны сайн туршлага, Монгол Улсын Их Хурлын 2019-өөс 2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлын судалгаанд тулгуурлан боловсруулахад Тамгын газар мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын тал бүрийн дэмжлэг үзүүлж ажилласан болно.

2 дугаар бүлэг. Улсын Их Хурал Хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах, эрх зүй, зохион байгуулалтын шинэтгэл хийхэд мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, үр дүнд хүрч байна. Улсын Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан хянан шалгах үйл ажиллагаанд цөөнхийн оролцоог хангах, хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлыг тодорхой болгох, сонсгол явуулах хүсэлт гаргах гишүүдийн тоо, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн, иргэний нийгмийн болон төрийн хяналт шалгалтын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зарчмын өөрчлөлтүүд хэрэгжиж байна.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа Хянан шалгах түр хороод үйл ажиллагаандаа зориулан төсөв, хөрөнгө зарцуулж эхэлсэн билээ. Улсын Их Хурлын шийдвэр хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавих, дүн шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох тайланг хэлэлцүүлүүлэх, Улсын Их Хурлын гишүүдийг хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээллээр хангах эрх зүйн орчин сайжирч, хэрэгжиж байна. Парламентын хяналтын өнөөгийн нөхцөл байдал, тулгарч байгаа бэрхшээл, шийдвэрлэх арга зам, талуудын оролцоог хангах, парламентын хяналтын дунд, урт хугацааны бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхой болгох асуудлыг парламентын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чуулга уулзалтаар хэлэлцэв.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдээс Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын парламент.мн цахим системээр дамжуулан ирүүлсэн 499 өргөдлийг хүлээн авч, хуульд заасан шаардлага хангасан 116 нийтийн өргөдөлд олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулж, саналыг нь авсан билээ. Эдгээрээс газрыг гадаадын иргэнд 100 жилээр ашиглах, эзэмших, цуцлах асуудалд 100167 иргэний дэмжлэг авч, энэ асуудлаар нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөл санаачилж, Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэн эцэслэн батлуулах ажилд арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж ажиллалаа.

Мөн Утааны сонсгол хийцгээе, төсвийн зарцуулалтын хяналт үнэлгээ хийж, сайжруулцгаая асуудлыг 71452 иргэн дэмжсэн. Энэ асуудлаар Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын

19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулалтын үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, 4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эдгээр хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 194 иргэн, төрийн байгууллагын 193 албан тушаалтан оролцож, 75 иргэн холбогдох төрийн байгууллагаас асуулт асууж, хариулт авч, 28 иргэн танилцуулга хийх ажлыг зохион байгуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж ажилласан.

3 дугаар бүлэг. Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, парламентат ёсыг бэхжүүлэх, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, ажиллаж байна. Улсын Их Хурал түүний Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт, Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, тов, дараалал, нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн ирцийн мэдээлэл, хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нийт хугацааг хувь тэнцүүлэн хуваарилж, нэгдсэн хуралдаан болон Байнгын хороо, ажлын хэсгийн хуралдааны товч, дэлгэрэнгүй тэмдэглэлийг парламент.мн цахим хуудсанд ил тод, нээлттэй мэдээлж байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд түгээх ажилд технологийн ололтыг ашиглаж, 208 постер, 266 инфографик, 129 видео мэдээ, 220 контент, хууль сурталчлах чиглэлээр 20 шторк, 234 рийлс видео, news letter 3 удаа бэлтгэн бүтээлээ, түгээлээ. Улсын Их Хурлын албан ёсны парламент.мн цахим хуудсаар болон нийгмийн сүлжээ, сүлжээгээр мэдээ мэдээллийг дамжуулсан ба дагагчдын тоо тодорхой хувиар өссөн болно.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон улсад сурталчлан мэдээлэх зорилгоор Улсын Их Хурлын албан ёсны парламент.мн цахим хуудсанд англи хэлээр мэдээ, мэдээллийг тогтмол нийтэлж байгаагаас гадна олон улсад нэр бүхий цахим хуудаснуудаар Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаар ярилцлага, мэдээ нийтлүүлж, медиа коннект платформ дээр хэвлэлийн мэдээ байршуулж ажиллаж байна.

Мөн түүнчлэн Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтээс үзэхэд давхардсан тоогоор 1,4 сая орчим иргэнийг оролцуулсан 300 гаруй төрлийн арга хэмжээг зохион байгуулсан байна. Ойг тохиолдуулан Улсын Их Хурлаас “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 43 дугаар тогтоолыг батлан гаргахад Улсын Их Хурлын гишүүддээ мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажилласан болно.

Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүд, Ерөнхий нарийн бичгийн даргын гадаад улсад хийсэн 10 айлчлалын болон гадаад улсын парламентаас манай улсад хийсэн 10 айлчлалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлсэн нь олон талт хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон байна.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын төлөөлөгчид Олон улсын парламентын холбооны 148 болон 149 дүгээр чуулга уулзалт, олон улс, бүс нутгийн байгууллагуудын ээлжит хурал, чуулга, хэлэлцүүлэгт оролцож, олон талт хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж, өргөжүүллээ. Парламент хоорондын

Найрамдлын бүлгүүдийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх уулзалтуудыг зохион байгуулсан болно. Эдгээр арга хэмжээний үеэр бусад орны парламентын төлөөлөгчидтэй хоёр талын уулзалт хийж, хууль тогтоох байгууллагууд хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, уламжлалт найрсаг харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

Сүүлчийн бүлэг буюу 4 дүгээр бүлэг. Улсын Их Хурал, түүний гишүүдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд ажиллах нөхцөлөөр хангах үйл ажиллагааг боломжит нөөц, хүчээ дайчлан зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрч байна. Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурал үйл ажиллагаагаа эхлэхэд шаардагдах бэлтгэлийг хангах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим, түүний тавилга, тоног, төхөөрөмж, цахим системийг иж бүрэн шинэчлэл, хуралдааны бусад танхимыг засварлан сайжруулсан болно. Үүний зэрэгцээ 126 гишүүний хурлын болон албан өрөөний урсгал засвар, тавилга, техник хэрэгслийг шинэчилж, ажиллах орчин нөхцөлөөр үе шаттайгаар хангаж ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 77 дугаар тогтоолын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн барилгыг Тамгын газарт шилжүүлэн авч, засвар шинэчлэл хийж, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн болон Тамгын газрын холбогдох.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тайлан сонслоо. Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя, Болормаа гишүүнийг нэмээрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх гээд Тамгын газар үйл ажиллагаа явуулахаар байгаа. Тэгээд Тамгын газар нь Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр үйл ажиллагааныхаа тайланг танилцуулахаар байгаа. Ингээд 2024 оны тайланг сонслоо. Тэгээд ойрхон ажиллаж байсан болохоор нэг их айхтар зүйл хэлээд байх зүйл алга.

Хамгийн гол нь Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Байнгын хороодынхоо үйл ажиллагаа, Улсын Их Хурлын чуулгантай холбоотой, орж ирж байгаа хуулиудтай холбоотой зарим нэгэн тайлбаруудыг зөв хийдэг байх, хууль зөрчихгүй байх, дэгээ баримтлах байх гэсэн энэ тал дээрээ цааш цаашдаа илүү их илүү анхаарч ажиллах нь зүйтэй байх гэдэг зүйлийг хэлье. Бусдаар нэг их айхтар хэлээд байх зүйл алга. Үндсэндээ Тамгын газар хуульд заасан үүргээ, хариуцлагаа зөв зүйтэй хийгээд явсан гэдгийг хэлье. Өөр зүйл алга. Амжилт хүсье та бүхэнд.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Уянгахишиг гишүүн нэрээ татлаа. Алтангэрэл гишүүн асуултаа, үг хэлье. Уянгахишиг гишүүн сая нэрээ татсан уу? Тийм.

О.Алтангэрэл: Тайлан сонслоо. Манай Тамгынхан хичээгээд сайн ажиллаж байгаа даа. Тэгэхдээ асуулт байгаа. Энэ Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн болон Тамгын газрын холбогдох нэгжүүдийг ажиллах нөхцөлийг бүрдүүллээ гээд. Тэгээд манай академич Амарсанаа академич тэгж байгаад л Хууль зүйн үндэсний төв хуульчид нэг

байшинтай болсон юм, тэгээд тэрийг нь авна гэж зүтгэсээр байгаад аваад л хажууд оруулсан. Одоо бол энд аягүй сайхан бахархалтайгаар тэгээд тэр барилгыг нь аваад, энэ хүмүүсээ оруулаад, ажиллах нөхцөлийг нь бүрдүүлээ энэ тэр гээд их сайхан биччихсэн байна.

Энэ тайлан дээр нэмж тодруулахад энэ Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн хэчнээн судалгаа хийв? Улсын Их Хурлын гишүүдээс судалгааны чиглэлээр хэчнээн чиглэлийн захиалга өгөв? Зөвлөх, туслахуудыг мэргэшүүлэх чиглэлээр юу хийв, ямар ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэв? Ийм тайлан байна уу? Энэ нэг том бүтэцтэй. Ер нь манай энэ Судалгааны хүрээлэнгээс хамгийн л том бүтэцтэй газар байж байдаг, маш их төсөв хөрөнгөтэй ийм газар байж байдаг. Тэгээд үйл ажиллагаа нь яг энэ бүтэц шигээ зарцуулагдаж байгаа, хөрөнгө мөнгө шигээ чиг үүргийн дагуу явагдаж ер нь чадаж байна уу гэсэн ийм асуулт байна?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, Баасандорж дарга хариулъя. 6 номер, Бумдарь захирал хариулъя.

Д.Бумдарь: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Манай Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн дээр энэ 5 давхар байшинд 6 нэгж байрладаг. 2 бүлэг, манай хүрээлэн, хяналт, санхүү, мөн Хуульчдын холбооны хэсэг, дээрээс нь Чимэд сангийнхан гэх мэтчилэн ингээд байрлаж байгаа. Тэгэхээр ганцхан манайх ашиглахгүй байгаа гэдгийг хэлье.

Манайх 9 сарын 17-нд тусдаа гарсан, өнгөрсөн 24 оны тайлан учраас 2 сар гаруйн үйл ажиллагааг тайлагнана гэж ойлгож болно. Тэгэхээр өнгөрсөн жилийн хүрээнд манайх нийтдээ 42 судалгаа хийсэн байна. 11 удаагийн сургалт явуулсан байна. Харин он гарснаар хагас жилийн хүрээнд манайх нийтдээ 100 судалгаа, 27 сургалтыг хийсэн байгаа. Өнгөрсөн жилээс онцолж хэлбэл мэдээж шинэ гишүүдийн сургалт болон Тамгын албан хаагчид, мөн зөвлөх, туслахын сургалт гэж хийж байгаа. Сая өнгөрсөн долоо хоногт хагас жилээр гишүүдэд зориулсан, гишүүдийн зөвлөх, туслахуудад зориулсан сургалтын тайлан, хөтөлбөрийг та бүхэн рүү илгээсэн байгаа. Тэгэхээр сая манай Ерөнхий нарийн бичгийн даргаас бүтэн тайланг уншиж чадсангүй байх. Тараасан зүйл дээр бүх хийгдсэн үйл ажиллагаанууд бүгдээрээ дурдагдаад явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүн ахиад тодруулж асууя.

О.Алтангэрэл: Тараасан зүйл дээр байгаа гэдэг нь тараасан зүйл нь юу юм доо? Тэгээд ийм хүн захирал нь байдаг юм байна, ярьж байгаа тоогоороо бол зөндөө юм хийчихсэн гэж ярьж байгаа юм байна. Тэгээд тэрийг нь харъя даа. Ер нь маш чухал үүрэгтэй байгууллага гэдгээ л ойлгоосой гэдэг. Бүгдээрээ хуульч байдаггүй, орж ирж байгаа хууль болгон зөвхөн хуульч хүмүүс мэддэг зүйл байдаггүй. Энэ судалгаа, судалгаанд тулгуурласан шийдвэр гаргалт гэдэг маш чухал шүү. Өөрийнхөө байгууллагын үйл ажиллагааг сайн ойлгуулж, гишүүддээ ойлгуулж, ам хэлээрээ биш, үйлдэл, үйл ажиллагаагаараа ойлгуулж ингэж ажиллаарай. Маш чухал байгууллага удирдаж байна шүү гэж ингэж л хэлье дээ.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Тамгын газрын удирдлагууддаа өдрийн мэнд хүргэе. Парламент шинэ 9 дэх удаагийн сонгуулиар бүрэлдсэн парламент буюу 126 гишүүнтэй парламент үйл ажиллагаа явуулаад яг нэг жилийн хугацаа болж байна. Энэ хугацаанд хийж, хэрэгжүүлсэн ажлынхаа тайланг тавьж байна. 1 дүгээрт ер нь энэ нэг жилийн хугацаанд хийж, хэрэгжүүлсэн ажлууд олон байгаа. Хамгийн гол асуудал маань бид өнгөрсөн 8 удаагийн парламентаар 76 гишүүнтэй байсан бол 126-тай болж өөрчлөгдсөн нь өөрөө шилжилт, шинэчлэл аль, аль нь явагдаж байгаа юм.

Улсын Их Хурал Стратеги, төлөвлөгөөгөө батлаад, хэрэгжүүлээд эхэлж байна. Дээр нь энэ Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн үр дүн нэлээдгүй гараад эхэлчихсэн байж байгаа. Энийгээ Тамгын газар нэг тодорхой надад хариулаад, ийм ажлын хэсгүүд гараад, үйл ажиллагаа нь ийм хэдэн хувьтай, ингээд, ингээд явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Дараагийн асуудал энэ Судалгааны хүрээлэнгийн хувьд би Алтангэрэл гишүүнээс арай эсрэг байр суурь илэрхийлнэ. Ер нь зүгээр бид энэ аливаа асуудал судалгаа дээр суурилж, бид энэ төрийн гарах шийдвэрүүд, хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлт, үнэлэмжүүд нь энэ дээрээ хэрэгжээд явах ёстой байх. Зүгээр тэр байшин савны асуудлын хувьд арай нөгөө өөр зүйл байхыг үгүйсгэхгүй. Би бас хуульчдын тэр Хууль зүйн үндэсний хүрээлэн байсан байшин гэдгээр нь, тэр агуулгаар нь тэрийг хүндэтгэх ёстой гэж үзэж байгаа.

Зүгээр парламентын үйл ажиллагаа доголдох ёсгүй гэдэг агуулга аль алин дээрээ. Бид цаашдаа энэ парламентын засаглал улам бэхжих ёстой. Тэр агуулгаараа энэ дээр нэлээдгүй анхаарал хандуулж, энэ судалгаанд суурилсан шийдвэрүүдийг цаашдаа гаргаж явах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Ёс зүй, дэгийн байнгын хороог удирдаж ажиллаа. Ингээд маргааш Их Хурлын тухай хууль батлагдсанаар 4 Байнгын хороо чиг үүргийнхээ хувьд бусад Байнгын хороод руу нэгтгэгдээд, ингээд татан буугдаж байгаа. Энэ хугацаанд Ёс зүй, дэгийн байнгын хорооны чиг үүргийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүй, соён гэгээрүүлэх хөтөлбөр, хуулийн хэрэгжилт гээд энэ олон зүйлүүд дээр Байнгын хороог чиглүүлж ажиллахыг хичээлээ. Энэ хугацаанд дэмжлэг болж ажилласан Тамгын газрын удирдлагууд, албан хаагчид, энэ хуралдаан зохион байгуулахад хүртэл техник хэрэгслээр нь хангаж байсан нийт албан хаагчдадаа Байнгын хорооны даргын хувьд талархал илэрхийлэх нь зөв байх гэж би бодож байна. Тэгээд цааш цаашдаа үйл ажиллагаагаа нэлээдгүй эрчимжүүлж ингэж ажиллах зайлшгүй шаардлага байгаа. Хамтдаа энэ чиглэл рүүгээ энэ төлөвлөгөөгөө гаргаад, энэ Стратеги, төлөвлөгөөнүүддээ суурилаад үйл ажиллагаагаа явуулъя гэсэн ийм саналыг хэлье.

1 асуулт байгаа. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн үр дүнг Баасандорж дарга та нэг тайлбарлаж өгнө үү гэдэг асуулт байна?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж: Баярбаатар гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын даргаас нийтдээ 60 гаруй ажлын хэсэг гарч ажилласан. Зарим ажлын хэсгүүд маань яг үр дүнтэй ажиллаад, өнөөдрийн байдлаар жишээ нь Мандхай гишүүнээр ахалсан ажлын хэсэг Хүнсний аюулгүй байдлын тухай, Хөдөө аж ахуйн тухай холбогдох хуулийн төслүүдээ Улсын Их Хуралд хэлэлцүүлээд, өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь шийдээд, Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад явж байгаа. Мөн Ганмаа гишүүний Эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой хуулийн ажлын хэсэг санал, дүгнэлтээ гаргачихсан, Улсын Их Хуралд танилцуулаад явж байгаа гэх мэт яг манай салбар салбарын чиглэлийн манай Байнгын хороодоос, Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээгээрээ манай ажлын хэсгүүд бол ажлын хэсгийн үр дүнгээ Байнгын хороодод танилцуулаад явж байгаа гэдгийг хэлье. Үр дүнгээр ер нь 50-иас дээш хувьтай ажиллаж байгаа ажлын хэсгүүд.

Сая Баярбаатар дарга, Алтангэрэл гишүүн, Алтангэрэл сайд 2 маань чухал асуудлыг хөндлөө. Манай Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн байгуулагдаад жил арай хүрээгүй байна. Жил хүрэх гэж байна. Бид бүхэн энэ Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнг Тамгын газрын дэргэд байгуулахдаа энэ Европын холбооны улс, Америк, Солонгос, Азийн орнуудаас Солонгосын сайн туршлагыг нэлээн судалсан. Ер нь бусад орнуудад ингээд харахаар яг энэ Парламентын судалгааны хөгжлийн хүрээлэндээ илүү анхаардаг. Яг тэр хууль тогтоох процесс нь өөрөө яг судалгаа, шинжилгээний үндсэн дээр тэр хууль тогтоох процесс нь явдаг дээр илүү анхаардаг юм байна лээ.

Манай Монгол Улсад судалгаа, шинжилгээний байгууллагууд байгаа юу гэвэл байгаа. Шүүх дээр байна, Хуулийн яаманд байна, манай парламент дээр байна, манай эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд дээр байна, сургуулиуд дээр байна. Харамсалтай нь энэ байгууллагууд маань хоорондоо уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, сайн туршлага хуваалцах зүйл нь төдийлөн сайн хөгжөөгүй юм байна лээ. Илүү хоорондоо уралдчихдаг. Тэр хүрээлэн ингэж явж байна, энэ хүрээлэн ийм төсөвтэй байна, манай хүрээлэн ийм төсөвтэй байна ингэж явдаг. Манай Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн маань яг байгуулагдаад ажилласан хугацаандаа Шүүхийн дэргэдэх судалгааны хөгжлийн хүрээлэнтэй хамтын ажиллагааны хүрээнд зорилго, төлөвлөгөөнүүдээ гаргасан. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хууль зүйн үндэсний хүрээлэнтэйгээ хэрхэн, яаж хамтарч ажиллах вэ, Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, МУИС-ийн судалгаа, шинжилгээний байгууллагуудтайгаа ер нь бид байгаа судалгаануудаа хэрхэн, яаж байгаа дата дээрээ дүн шинжилгээгээ хийгээд, цаашаа судалгаануудаа тал талаас нь анхаарч, яаж чанартай судалгаа хийх талаар ер нь нэлээд голлож, анхаарч ажиллаж байгаа Алтангэрэл сайдаа, Баярбаатар даргаа.

Мэдээж нэг жил хүрээгүй хугацаанд бид хангалттай ажилласан уу гэвэл би бол хангалттай ажилласан гэж хэлэхгүй. Яг тодорхой 100 хувь бол ажиллаагүй. Гэхдээ тодорхой түвшинд гишүүдийнхээ гаргасан саналуудын дагуу судалгаануудыг хийсэн. Харин ирэх 3 жил бид илүү энэ судалгааныхаа чанаруудыг, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар онцгой анхаарч ажиллана гэдгээ Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүддээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн тодруулъя.

Б.Баярбаатар: Баярлалаа. Тэгээд дахиад энэ парламентын бүрэн эрх дуусахад 3 жилийн хугацаа байна. Тэгээд бид нөгөө стратеги, зорилт 1 дүгээрт хүн

төвтэй хууль, хууль, эрх зүйн орчин, 2-т энэ дарга буюу дарга төвтэй буюу энэ авлигажсан гэж яриад байгаа хуулиас давсан журмуудыг цэгцлэх асуудал, 3-т энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийдэг байх гэсэн энэ 3 зүйл дээр бид энэ 4 жил ерөөсөө хийх ёстой ажил маань энэ байгаа юм. Тэгээд энэнийхээ хүрээнд тайландаа тусгаж, хэдэн хууль дээр ийм хүний эрхийн зөрчилтэй асуудлууд ингэж, ингэж цэгцлэгдсэн, хуулиудын үнэлгээ ингэж, ингэж хийгдсэн, журмууд, журмаар зохицуулдаг асуудлыг хуульчилсан байдал нь энэ байна, эргээд журмыг сайжруулсан байдал энэ байна гээд тэгсэн ийм зүйлүүдийг жилийн дараах тайлан дээрээ та тусгаж орж ирээд, үнэлүүлбэл их зүгээр байна гэдэг саналыг хэлчихье. Амжилт хүсье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ганц нэг зүйл хэлье. Маргааш үндсэндээ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль эцсийн хэлэлцүүлэг рүүгээ орсон байгаа. Энэ хуулиар 11 одоогийн Байнгын хороо маань 8 Байнгын хороо болж байгаа. 4 Байнгын хороог татан буулгаад, 1 Байнгын хороог нь шинээр сэргээж байгаа. Өргөдлийн байнгын хороог сэргээж, үйл ажиллагааг эхлүүлж байгаа.

Одоо Байнгын хороод маань дунджаар дээд тал нь 25 гишүүнтэй байгаа. Тэгэхээр шинэ хууль батлагдсанаар Байнгын хороод 32, 33 гишүүнтэй болохоор байгаа. Тэгэхээр энэ Байнгын хороодынхоо ажлын албыг бэхжүүлэх, хүн хүчний хүрэлцээ хангамжийн асуудал дээр нь Баасандорж дарга анхаарал хандуулахгүй бол одоо байгаа 2, 3 хүн чинь хаанаа ч хүрэлцдэггүй юм байна лээ шүү гэдгийг анхаарна биз дээ.

Цаашдаа Өргөдлийн байнгын хороог сэргээж байгаа нь хууль тогтоох үйл ажиллагаанд ард иргэдийн санал, хүсэлтийг авах, тусгах энэ чиглэлээр байгуулагдаж байгаа гэдгийг хэлье. Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Улсын Их Хурлын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа.

15.53 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА